



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ  
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны тавдугаар сарын 28

№20 (449)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

265.	Хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай	578
266.	Нийгмийн халамжийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай	579
267.	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай	579
268.	Монгол Улсын татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай	580
269.	Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуульд нэмэлт оруулах тухай	580
270.	Монгол улсын нэгдсэн төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	580

### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

271.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний тангараг өргөх журам батлах тухай	Дугаар 40	581
272.	Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай	Дугаар 41	582

### Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

273.	2006 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох тухай	Дугаар 73	582
274.	Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэх тухай	Дугаар 75	584
275.	Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай	Дугаар 79	585
276.	Ажлаас чөлөөлөх, ажилд түр томилох тухай	Дугаар 80	585
277.	Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 81	585
278.	Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 82	585
279.	Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай	Дугаар 83	586
280.	Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 85	586
281.	Талбайн хэмжээг тогтоох тухай	Дугаар 87	587
282.	Ажилд томилох тухай	Дугаар 90	588
283.	"Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 91	588
284.	Хөтөлбөр батлах тухай	Дугаар 93	591
285.	Ажлаас чөлөөлөх, ажилд түр томилох тухай	Дугаар 95	597
286.	"Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр" батлах тухай	Дугаар 99	597

2006 оны 5 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

## ХҮҮХДЭД ТЭТГЭМЖ ОЛГОХ, ХҮҮХЭД, ГЭР БҮЛД МӨНГӨН ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭХ ТУХАЙ

### 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хүүхдэд тэтгэмж олгох, шинээр гэрлэгчид болон төрсөн хүүхдэд нэг удаа мөнгөн тусламж /цаашид "тэтгэмж, тусламж" гэж/ үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

### 2 дугаар зүйл. Хууль тогтоомж

2.1. Энэ хуулиар тогтоосон тэтгэмж олгох, мөнгөн тусламж үзүүлэх тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

### 3 дугаар зүйл. Хуульд хэрэглэсэн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "хүүхэд" гэж 0-18 хүртэлх насны Монгол Улсын иргэнийг;

3.1.2. "шинээр гэрлэгчид" гэж анх удаа гэрлэж, төрийн эрх бүхий байгууллагад гэрлэлтээ бүртгүүлсэн Монгол Улсын иргэнийг;

3.1.3. "анх удаа гэрлэх" гэж гэрлэгчдийн аль аль нь урьд нь өөр хүнтэй гэрлэж байгаагүйг.

### 4 дүгээр зүйл. Төрөөс олгох тэтгэмж, тусламж

4.1. Энэ хуулийн 3.1.1-д заасан хүүхэд сар тутам тэтгэмж авах эрхтэй.

4.2. Энэ хуулийн 3.1.2, 3.1.3-т заасан нөхцөл хангасан шинээр гэрлэгчид төрөөс нэг удаа мөнгөн тусламж авах эрхтэй.

4.3. 2006 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойш төрсөн хүүхэд төрөөс нэг удаа мөнгөн тусламж авах эрхтэй.

4.4. Гадаад улсын нутаг дэвсгэрт түр амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж олгож болно.

4.5. Харьяатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчиж хоёрдмол харьяалалтай болсон иргэний хүүхдэд энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж олгохгүй.

### 5 дугаар зүйл. Хүүхдийн тэтгэмж олгох нөхцөл

5.1. Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмжийг дор дурдсан нөхцөлд олгоно:

5.1.1. хүүхэд гэр бүлдээ амьдарч байгаа;

5.1.2. сургуулийн насны хүүхэд сургуульд хамрагдсан.

### 6 дугаар зүйл. Бүрдүүлэх баримт бичиг

6.1 Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж авахын тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

6.1.1. хүүхдийн төрсний гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

6.1.2. эцэг /эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн иргэний үнэмлэхийн буюу түүнтэй адилтгах баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

6.1.3. энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан нөхцөл хангаж байгааг нотолсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан /баг, хорооны Засаг дарга, сум, багийн болон өрхийн эмч, сургууль/-ны тодорхойлолт;

6.1.4. Гэр бүлийн тухай хуулийн 66.1-д заасны дагуу асран хамгаалагч, харгалзан дэмжигчээр тогтоогдсон бол сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;

6.2. Энэ хуулийн 4.2-т заасан тусламж авахын тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

6.2.1. гэрлэлтийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

6.2.2. гэрлэгчдийн иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

6.2.3. баг, хорооны Засаг дарга, Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тодорхойлолт;

6.2.4. энэ хуулийн 3.1.3-т заасан нөхцөл хангаж байгааг нотолсон иргэний бүртгэл, мэдээллийн албаны лавлагаа.

6.3. Энэ хуулийн 4.3-т заасан тусламж авахын тулд дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

6.3.1. хүүхдийн төрсний гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

6.3.2. хүүхэд эсэн мэнд бойжиж байгаа тухай сум, баг, өрхийн эмчийн тодорхойлолт;

6.3.3. баг, хорооны Засаг дарга, Монгол Улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газрын тодорхойлолт.

6.4. Тэтгэмж, тусламж авахыг хүссэн иргэн өргөдөл болон энэ хуулийн 6.1-6.3-т заасан баримт бичгийг бүрдүүлж дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, эсхүл сумын нийгмийн ажиглалтанд өгнө.

6.5. Хүүхэд асран хүмүүжүүлэх улсын байгууллага болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг асрамжийн байгууллагад хүмүүжиж байгаа бүтэн өнчин, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч нь тогтоогдоогүй хүүхдэд тухайн байгууллагын тодорхойлолтоор энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж, 4.3-т заасан тусламж олгоно.

6.6. Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 6.4, 6.5-д заасан баримт бичиг болон нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, эсхүл нийгмийн ажилтны саналыг үндэслэн тэтгэмж олгох буюу тусламж үзүүлэх тухай захирамж гаргана.

### 7 дугаар зүйл. Тэтгэмж олгох, мөнгөн тусламж үзүүлэх



7.1. Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж, 4.2, 4.3-т заасан тусламж олгох ажлыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

7.2. Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж, 4.3-т заасан тусламжийг хүүхдийн эцэг /эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-т олгоно.

7.3. Нийгмийн халамж, үйлчилгээний байгууллага тэтгэмж тусламж авагчийн хүсэлтээр тэдгээрийг хадгаламжид шилжүүлэх буюу арилжааны банкаар дамжуулан олгож болно.

7.4. Асран хүмүүжүүлэх байгууллагад хүмүүжиж байгаа хүүхэд бүрийн нэр дээр хадгаламжийн данс нээн тэтгэмжийг сар бүр шилжүүлнэ.

**8 дугаар зүйл. Тэтгэмж, тусламжийн хэмжээ, тэдгээрийг олгох хугацаа**

8.1. Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмж, 4.2, 4.3-т заасан тусламжийн хэмжээг Улсын Их Хурал тогтооно.

8.2. Энэ хуулийн 4.1-д заасан тэтгэмжид

шинээр хамрагдах хүүхдэд 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тэтгэмж олгоно.

8.3. Энэ хуулийн 4.2, 4.3-т заасан тусламжийг 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн олгоно.

**9 дүгээр зүйл. Хууль тогтоомж зорчигчид хүлээлгэх хариуцлага**

9.1. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр энэ хуульд заасан тэтгэмж, тусламж тогтоолгосон гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол улсын байцаагч 10000-50000 төгрөгөөр торгоно.

9.2. Тэтгэмж, тусламжид хамрагдах иргэний тодорхойлолтыг үндэслэлгүйгээр болон хуурамчаар үйлдсэн албан тушаалтан, нийгмийн ажилтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Нийгмийн халамжийн тухай хуулийн 35.2-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 5 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

**НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ,  
ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 23

дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

**ЗАРИМ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН  
ӨСӨЛТИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нэмэгдэл орлогод албан татвар ногдуулах, түүнийг тусгай санд төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Хууль тогтоомж**

2.1. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл. Албан татвар ногдуулах бүтээгдэхүүн**

3.1. Дор дурдсан бүтээгдэхүүнд үнийн өсөлтийн нэмэгдэл орлогын албан татвар ногдуулна:

3.1.1. алт;

3.1.2. зэсийн хүдэр болон баяжмал.

**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо**

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "зэсийн үнийн өсөлтийн нэмэгдэл орлого" гэж Лондонгийн металлын бирж дээрх зэсийн үнээс энэ хуулийн 4.1.2, 4.1.3-т заасан үнэ, зардлыг хассаны дараа үлдсэн орлогыг;

4.1.2. "зэсийн суурь үнэ" гэж хүдэр олборлох болон баяжмал үйлдвэрлэхэд гарсан зардал дээр ашгийг 100 хувиар тооцож нэмсэн дүнг;

4.1.3. "зэс хайлуулах зардал" гэж түүнийг хайлуулах, цэвэршүүлэх болон энэхүү үйл ажиллагаатай шууд холбогдож гарах зардлыг;

4.1.4. "алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого" гэж Лондонгийн металлын бирж дээрх 1 унци алтны үнээс 500 ам долларыг хассаны дараа үлдсэн орлогыг.

**5 дугаар зүйл. Албан татвар төлөгч**

5.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт олборлосон, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан бүтээгдэхүүнийг борлуулсан хувь хүн, хуулийн этгээд энэ хуулийн дагуу албан татвар төлөгч байна.

**6 дугаар зүйл. Татвар ногдуулах орлогыг тодорхойлох**



6.1. Энэ хуулийн 3.1.2-т заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх зэсийн үнээс энэ хуулийн 4.1.2, 4.1.3-т заасан зардал, үнийг хасч тооцно.

6.2. Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо Лондонгийн металлын бирж дээрх 1 унц и алтны үнээс 500 ам долларыг хасч тооцно.

6.3. Энэ хуулийн 3.1.2-т заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо нэг тонн зэсийн суурь үнийг 2600 ам. доллароор тооцно.

**7 дугаар зүйл. Татварын хувь хэмжээ**

7.1. Энэ хуулийн 6.1, 6.2-т заасны дагуу тодорхойлсон орлогоос 68.0 хувиар тооцож албан татвар ногдуулна.

**8 дугаар зүйл. Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох, татварыг тусгай санд төлөх, тайлагнах**

8.1. Албан татвар төлөгч нь энэ хуульд заасан албан татвар ногдуулах орлогыг өөрөө үнэн зөв тодорхойлж татварыг тусгай санд төлнө.

8.2. Энэ хуульд заасан бүтээгдэхүүн борлуулсан этгээд нь албан татвар төлсөн тайланг татварын хууль тогтоомжид заасан хугацаанд гаргаж, татварын албанд ирүүлнэ.

8.3. Энэ хуулийн 8.2-т заасан тайлангийн маягтыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

**9 дүгээр зүйл. Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих**

9.1. Энэ хуулийн хэрэгжилтэд татварын алба хяналт тавих бөгөөд хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон аргачлал, зааврыг Үндэсний татварын ерөнхий газрын дарга батална.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд " 9/ зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар." гэсэн заалт нэмсүгэй.

тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварын хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "үл хөдлөх эд хөрөнгийн" гэсний дараа "болон зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн" гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хуульд дөр дүрдсэн агуулгатай заалт, хэсэг нэмсүгэй:

"9.1.9. зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар."

1/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт.

2/ 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:  
"13.4. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлогоор Монгол Улсыг хөгжүүлэх сан байгуулна."

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль хүчин

төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 5–ны өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

### Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний тангараг өргөх журам батлах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2.Энэ тогтоолыг 2006 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүний тангараг өргөх журмыг хавсралтаар баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

*Монгол Улсын Их Хурлын 2006 оны 40 дүгээр тогтоолын хавсралт*

### СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ГИШҮҮНИЙ ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

1.Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороо /цаашид "Хороо" гэх/-ны гишүүн томилогдсоноосоо хойш 21 хоногийн дотор Монгол Улсын Үндсэн хуульд тангараг өргөнө.

8.Хорооны гишүүн Монгол Улсын Үндсэн хууль дээр баруун гараа тавьж тангаргийг цээжээр дуудсаны дараа Монгол Улсын Төрийн сүлднээ мэхийн ёсолж зүүн өвдөг дээрээ сөхрөн Төрийн далбаанаас адис авна.

2.Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга тангараг өргөх газар, хугацаа /өдөр, цаг/-ийг Хорооны даргатай зөвшилцөн тогтоох бөгөөд төрийн ёслолын алба тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангаж зохион байгуулна.

9.Хорооны гишүүн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд хамгийн ахмад нь Монгол Улсын Үндсэн хууль дээр баруун гараа тавьж тангаргийг цээжээр дуудаж, бусад нь дагалдана.

3.Тангараг өргөх ёслолын ажиллагаанд төр, захиргаа, хэвлэл, мэдээллийн байгууллагын төлөөлөгчдийг урилгаар оролцуулж болно.

10.Тангараг өргөж байх үед уг ёслолын ажиллагаанд оролцогчид босож хүндэтгэнэ.

4.Тангараг өргөх байранд Монгол Улсын Төрийн сүлд, түүний баруун гар талд Төрийн далбааг байрлуулна.

11.Тангараг өргөсний дараа Хорооны гишүүн тусгайлан бэлтгэсэн тангаргийн хуудсанд гарын үсэг зурна.

5.Тусгайлан бэлдсэн ширээн дээр Үндсэн хууль, тангаргийн бичиг, үзэг тавьсан байна.

12.Тангаргийн хуудсанд Монгол Улсын Төрийн сүлд, түүний дор тангаргийн бүрэн бичвэр, тангараг өргөсөн газрын болон Хорооны гишүүний нэр, он, сар, өдрийг тусгана.

6.Хорооны гишүүн товлосон өдөр, цагт тангараг өргөх байранд орж Монгол Улсын Төрийн сүлд рүү харан цэх зогсох ба хамтаар тангараг өргөх бол эгнэн зогсоно.

13.Гишүүд тангаргийн хуудсанд гарын үсэг зурж дууссаны дараа Төрийн дуулал эгшиглэх бөгөөд энэ үед танхимд байгаа бүх хүн босож хүндэтгэнэ.

7.Тангараг өргөх ёслолын ажиллагааг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга удирдан явуулах ба тэрээр нээлтийн эхэнд Хорооны гишүүн бүрийг цагаан толгойн үсгийн дарааллаар танилцуулна.

14.Төрийн дуулал эгшиглэж дуусмагц Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга тангараг өргөсөн Хорооны гишүүдэд баяр хүргэж ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэнэ.



15. Хорооны гишүүний гарын үсэг зурж баталгаажуулсан тангаргийн бичгийг Хорооны архивт хадгална.

16. Тангаргаг өргөх ёслолын ажиллагааны талаархи дэс дарааллыг тодорхой тусгасан тэмдэглэл хөтөлнө.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

### Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сайдаар Сайнбуянгийн Отгонбаярыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 5 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

1. Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Онцгой байдлын асуудал эрхэлсэн

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

### 2006 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний хувийг тогтоох тухай

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 4.1.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн 2006 онд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг дор дурдсанаар тогтоосугай:

а/эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан байгууллага, аж ахуйн нэгжийн гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг хавсралтад зааснаар;

б/энэхүү тогтоолын хавсралтад заагдаагүй салбар болон шашны байгууллагад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт ажиллагчдын 5 хүртэл хувь байхаар;

в/боловсролын байгууллагад ажиллах гадаадын ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг нийт ажиллагчдын 30 хувь хүртэл, гадаад хэлээр дагнан үйл ажиллагаа явуулдаг бслэвсрэл, шинжлэх үхээнэ байгууллагад 40 хүртэл хувь байхаар;

г/гадаадын төрийн бус, хүмүүнлэг, тусламжийн байгууллага болон гадаадын аж ахуйн

нэгж, байгууллагын төлөөлөгчийн газарт 40 хүртэл хувь байхаар.

2. Энэ тогтоолын хавсралтад заасан гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний нийт ажиллагчдын тоонд эзлэх хувийг Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, тендер зарлах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд баримтлахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

3. Гадаадын эзэл, тусламжийн хөрөнгөөр улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга байгууламж барихад энэ тогтоолд заасан хувийг баримтлах боломжгүй бол тухай бүр асуудлыг Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэдэд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гадаадаас 2005 онд авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай" Засгийн газрын 2005 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 9 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**

**М.ЭНХБОЛД**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

**Л.ОДОНЧИМЭД**

## ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРУУДАД 2006 ОНД ГАДААДААС АВАХ АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТНИЙ НИЙТ АЖИЛЛАГЧДЫН ТООНД ЭЗЛЭХ ХУВИЙ

Салбар, бүсчлэл	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	Дүрмийн сангийн хэмжээ (сая төгрөг)													
		50 хүртэл					100-500					500 ба дээш			
		100 хүртэл	101-500 дээш	100 хүртэл	101-500 дээш	101-500 дээш	100 хүртэл	101-500 дээш	100 хүртэл	101-500 дээш	100 хүртэл	101-500 дээш			
		<b>Нийт ажиллагчдын тоо</b>													
A01	<b>ХӨДӨӨ АЖ АХУЙ</b>	8	9	10	9	10	11	10	11	12	11	12	11	12	13
11	Газар тариалан	6	7	8	8	9	10	9	10	11	10	11	10	11	12
12	Эрчимжсэн мал аж ахуй	6	7	8	8	9	10	9	10	11	10	11	10	11	12
C	<b>Уул уурхай, олборлох үйлдвэрлэл</b>														
C10	Нууц олборлолт	6	7	8	8	9	10	9	10	11	10	11	10	11	12
C11	Газрын тос, шатагдах хийн хайгуул	70	80	90	90	90	90	90	90	90	90	90	90	90	90
C13	Алт болон бусад үнэт металлын эрэл хайгуул, олборлолт	23	28	33	28	33	38	33	38	43	34	39	34	39	44
C13	Төмрийн хүдэр олборлолт	6	7	8	7	8	9	8	9	10	9	10	9	10	11
D	<b>Төмрийн хүдэр олборлолт</b>														
D15	<b>БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРЛЭЛ</b>														
D15-153	Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10
D17-19	Нэхмэл, оёдол, явс шир боловсруулалт, бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10
D23	Кокс, шингэн болон цацраг идэвхт түлш үйлдвэрлэл	4	5	6	5	6	7	6	7	8	7	8	7	8	9
D24	Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	6	7	8	7	8	9	8	9	10	12	10	15	20	
D25	Разин, хуваагч, төмөрөг бус эрхэс бодисоор хийсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	10	12	
D27, 28	Төмрийн үйлдвэрлэл, төмөр эдлэл үйлдвэрлэл	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10
D	<b>Боловсруулах аж үйлдвэрийн бусад бүтээгдэхүүн</b>	8	9	10	9	10	11	10	11	12	11	12	11	12	13
E	Цахилгаан хий үйлдвэрлэл, ус хангамж	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10
D	Барилгын материалын үйлдвэрлэл, барилга угсралт	10	15	20	15	20	25	20	25	30	25	30	25	30	35
F	<b>АВТО ЗАМ БАРИЛГА</b>	15	20	25	20	25	30	25	30	35	30	35	30	32	35
G50	Бөөний болон жижиглэн худалдаа	12	14	16	14	16	18	16	18	20	18	20	18	20	22
H55	<b>ЗОЧИД БУУДАЛ, ЗООГИЙН ГАЗАР</b>	10	15	20	15	20	25	20	25	30	25	30	25	30	35
G50	Автомашин, мотоцикл, гэр ахуйн баруаны засвар, үйлчилгээ	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10
H60	<b>ТЭЭВЭР, ХОЛБОО, АГУУЛАХЫН АЖ АХУЙ</b>	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10
H	<b>АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛ</b>	10	15	20	15	20	25	20	25	30	25	30	25	30	35
O	<b>НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ ХҮН АМ, НИЙГЭМД ХЗҮҮЛЭХ БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ</b>	5	6	7	6	7	8	7	8	9	8	9	8	9	10

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр

Дугаар 75

Улаанбаатар хот

Дархлаажуулалтын тухай хуулийн 10.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсад мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Дархлаажуулалтын үндэсний шинэ товлолыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангасны үндсэн дээр 2006 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайд даалгасугай.

### Дархлаажуулалтын үндэсний товлолыг шинэчлэх тухай

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 129 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**
**М.ЭНХБОЛД**
**ЭРҮҮЛ МЭНДИЙН  
САЙД**
**Л.ГҮНДАЛАЙ**
**Монгол Улсын Их Хурлын 2006 оны 75  
дугаар тогтоолын хавсралт**

### МОНГОЛ УЛСАД МӨРДӨХ ЗААВАЛ ХИЙХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН ҮНДЭСНИЙ ТОВЛОЛ

№	Сэргийлэх тарилгын нэр	Эхлэл дархлаажуулалт	Дархлал сэргээх /давган/ дархлаажуулалт
1	Сүрьеэгийн эсрэг сэргийлэх тарилга (БЦЖ)	Төрсний дараа 24 цагийн дотор	
2	Полиомелиитийн (Хүүхдийн тархи нугасны халдаварт саа) эсрэг сэргийлэх тарилга	Нэг дэх тунг төрсний дараа 24 цагийн дотор Хоёр дахь тунг хоёр сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэг дэх тунг, В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын хоёр дахь тунгтай нэгэн зэрэг Гурав дахь тунг гураван сартайд нь сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын хоёр дахь тунгтай нэгэн зэрэг	
3	В вирус эсрэг тарилгын эсрэг сэргийлэх тарилга	Нэг дэх тунг төрсний дараа 24 цагийн дотор Хоёр дахь тунг хоёр сартайд нь полиомелиитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл, дархлаажуулалтын хоёр дахь тунг, сахуу, хөхүүл ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэг дэх тунгтай нэгэн зэрэг Гурав дахь тунг наймаас арван нэгэн сартайд улаанбурхны эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын нэг дэх тунгтай нэгэн зэрэг	
4	Сахуу, ханиад, татрангийн эсрэг сэргийлэх тарилга	Нэг дэх тунг хоёр сартайд нь полиомелиитын эсрэг сэргийлэх тарилгын боловч В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын хоёр дахь тунгтай нэгэн зэрэг	Хоёр настайд нь дархлал сэргээх дархлаажуулалтын нэг тунг хийнэ
5	Сахуу, татрангийн эсрэг сэргийлэх тарилга //Дархлал сэргээх тунг	Хоёр дахь тунг гураван сартайд нь полиомелиитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын гурав дахь тунгтай нэгэн зэрэг	Нэг дэх тунг 7 настайд Хоёр дахь тунг 15 настайд хийнэ
6	Улаанбурхны эсрэг сэргийлэх тарилга	Нэг дэх тунг наймаас арван нэгэн сартайд нь В гепатитын эсрэг сэргийлэх тарилгын эхлэл дархлаажуулалтын гурав дахь тунгтай нэгэн зэрэг Хоёр дахь тунг нэг насанд нь нэгдэх тунгаар дархлаажуулснаас хойш 6-10 сарын дараа хийнэ	

Тайлбар: Вакцины тунгийн хэмжээ, хэрэглэх аргыг тухайн вакцины шинж чанар, үйлдвэрлэлчийн зааварыг үндэслэн Эрүүл мэндийн яам тухай бүр тогтоож байна.



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 79

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өөр ажилд шилжсэн тул Раднаабазарын Алтангэрэлийг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Хасбазарын Бэxбатыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД  
ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

М.ЭНХБОЛД

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд түр томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Сүрэнгийн Баасанхүүг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Михлайн Борбаатарыг Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАТЛАН ХАМГААЛАХЫН  
САЙД

М.СОНОМПИЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай

Дипломат албаны тухай хуулийн 16.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадад ажиллах томилолтын хугацаа нь дууссантай холбогдуулан Самдангийн Чулуунбаатарыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суугаа Ерөнхий консулын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Цэрэндэмбэрэлийн Баасанжавыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөх хотод суух Ерөнхий консулаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 82

Улаанбаатар хот

Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай

Дипломат албаны тухай хуулийн 16.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадад ажиллах томилолтын хугацаа нь дууссантай холбогдуулан Намжилын Түмэндэмбэрэлийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод суугаа Ерөнхий консулын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Гэндэнгийн Төртөгтохыг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Улаан-Үд хотод суух Ерөнхий консулаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Ерөнхий консулыг томилох, чөлөөлөх тухай

Дипломат албаны тухай хуулийн 16.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадад ажиллах томилолтын хугацаа нь дууссантай холбогдуулан Ендонпунцагийн Адилбишийг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суугаа Ерөнхий консулын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2. Аюурзанын Базархүүг Монгол Улсаас Оросын Холбооны Улсын Эрхүү хотод суух Ерөнхий консулаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ГАДААД ХЭРГИЙН  
САЙД

Н.ЭНХБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Засгийн газрын комисс, хороо, үндэсний зөвлөл, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 2005 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн 66 дугаар тогтоолын 18 дугаар хавсралтаар баталсан Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2005 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 94 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА С.БАТБОЛД

*Засгийн газрын 2005 оны 66 дугаар тогтоолын 18 дугаар хавсралт*

### ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: -Засгийн газрын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Батболд

Дэд дарга: -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр

Гишүүд:

-Төв аймгийн Засаг дарга Ц.Энхбат;

-Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ч.Хүрэлбаатар;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Үндэсний бөхийн салбар хорооны дарга Н.Батсуурь;

-Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, Хурдан морины салбар хорооны дарга М.Борбаатар;

-Зам, тээвэр, аялал жуулчлалын дэд сайд, Үндэсний сурын салбар хорооны дарга Г.Шийлэгдамба;

-Барилга, хот байгуулалтын дэд сайд, Шагайн харвааны салбар хорооны дарга Ц.Дашдорж;

-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Төрийн ёслол үйлчилгээний салбар хорооны дарга Х.Бэхбат;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Урлаг, соёлын арга хэмжээний салбар хорооны дарга Б.Мишигжав;

-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батсэрээдэнз;

-Улаанбаатар хотын ерөнхий менежер, Тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний салбар хорооны дарга Г.Мөнхбаяр;

-Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны дарга, Хэвлэл мэдээлэл, сурталчилгааны салбар хорооны дарга С.Мягмар;

-Цагдаагийн ерөнхий газрын дарга, Хэв журмын салбар хорооны дарга Д.Сандаг-Очир;



-Төрийн ёслолын албаны дарга  
О.Нямдаваа;  
-Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга  
Ц.Уугангэрэл;  
-Биеийн тамир, спортын улсын хорооны  
дарга Ч.Наранбаатар;  
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
санхүү, эдийн засаг, төрийн сангийн хэлтсийн

ахлах мэргэжилтэн Ц.Долоонжин;  
-Эрүүл мэндийн шинжлэх ухааны их  
сургуулийн багш Ч.Ерөөлт.  
  
Нарийн бичгийн дарга;  
  
-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын  
дарга Ц.Болдсайхан.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр  
сарын 19-ний өдөр

Дугаар 87

Улаанбаатар  
хот

### Талбайн хэмжээг тогтоох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн  
26 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг үндэслэн Монгол  
Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2 дугаар сарын 12-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг  
хүчингүй болсонд тооцсугай.

1. Дархан цаазат болон байгалийн  
цогцолборт газарт нэг байгаль хамгаалагчийн  
хариуцах талбайн хэмжээг хавсралт ёсоор  
тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан  
"Норматив тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны

БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

Засгийн газрын 2006 оны 87 дугаар  
тогтоолын хавсралт

### БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧИЙН ХАРИУЦАХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ

/мян.га/

№	Хамгаалах газар нутгийн статус	Байгалийн бүс, бүслүүр				Цөлийн
		Өндөр уулын	Ойт хээрийн	Тал хээрийн	Цөлөрхөг хээрийн	
1	Дархан цаазат газар	50.0	40.0	90.0	100.0	200.0
2	Байгалийн цогцолборт газар	70.0	50.0	100.0	120.0	300.0

1. Улсын хил дамнасан тусгай  
хамгаалалттай газар, олон улсын ач холбогдол  
бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд  
олноор амьдардаг орчны тухай олон улсын конвенци  
/Рамсарын конвенци/, ЮНЕСКО-гийн хүн ба шим  
мандлын нөөц газрын жагсаалт болон дэлхийн  
байгаль соёлын өвд бүртгэгдсэн газар нутагт энэхүү

талбайн хэмжээг 10.0 хүртэл мян.га-гаар бууруулж  
тооцож болно.

2. Тухайн газар нутгийн байгалийн нөөц  
баялгийн ашиглалт, аж ахуйн нэгжийн тоо, үйл  
ажиллагаанаас хамааран байгаль хамгаалагчийн  
хариуцах талбайг дор дурдсан хэмжээгээр  
бууруулж болно:

№	Аж ахуйн нэгжийн тоо	Багасгаж болох талбайн хэмжээ /мян.га/
1	10 хүртэл	5 хүртэл
2	11-30	10 хүртэл
3	31-ээс дээш	20 хүртэл

3. Тусгай хамгаалалттай газар нутгийн  
хилийн заагаас гадагш 30 хүртэлх километр дотор  
орших хот, суурин газрын зэрэглэлээс

хамааруулан байгаль хамгаалагчийн хариуцах  
талбайг дор дурдсан хэмжээгээр бууруулж тооцож  
болно:

№	Суурин газрын зэрэглэл	Багасгаж болох талбайн хэмжээ /мян.га/
1	Нийслэл	20 хүртэл
2	Улсын зэрэглэлтэй хот	15 хүртэл
3	Аймгийн зэрэглэлтэй хот	10 хүртэл
4	Томоохон суурин, сумын төв	8 хүртэл



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 90

Улаанбаатар хот

Ажилд томилох тухай

Төсвийн байгууллагын удирдлага, томилсугай.

санхүүжилтийн тухай хуулийн 45.5, Төрийн албаны зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

Жамъянхорлоогийн Сүхбаатарыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд даргаар

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БАТБОЛД

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 91

Улаанбаатар хот

"Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөр батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 7.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл монгол хүн" үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 2006 онд шаардагдах 3.154 (гурван тэрбум нэг зуун тавин дөрвөн сая) тэрбум төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангийн үлдэгдэл хөрөнгөөс гаргах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Л.Одончимэд, Эрүүл мэндийн сайд Л.Гүндалай, Сангийн сайд Н.Баяртсайхан нарт даалгасугай.

3. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж явц, үр дүнг жил бүрийн П улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Эрүүл мэндийн сайд Л.Гүндалайд, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нутаг

дэвсгэрийнхээ хүн амыг бүрэн хамруулах, үзлэгийг шуурхай, чанартай явуулахад бүх талын дэмжлэг үзүүлэхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Мэдээллийн сан бүрдүүлэх, иргэдийг эрүүлжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа хувь хүний эрүүл мэндийн нууцыг чандлан хадгалж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын удирдлага, эмч, эмнэлгийн ажилтанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

Л.ГҮНДАЛАЙ

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД

Л.ОДОНЧИМЭД

Засгийн газрын 2006 оны 91 дүгээр тогтоолын хавсралт

## "ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэг үндэслэл

Сүүлийн жилүүдэд улс орны нийгэм, эдийн засагт хийсэн шинэчлэлийн нөлөөгөөр хүн амын өвчлөл, нас баралтын бүтцэд өөрчлөлт гарч хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээ өсөн нэмэгдэж байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр 1990 он гэхэд манай хүн амын нас баралтын шалтгааны эхний 2, 3 дугаарт зүрх судасны өвчин, хавдар ордог байсан бол 1993 оноос эхлэн нас баралтын шалтгааны дотор зүрх судасны өвчин тэргүүлж, хавдар, осол гэмтэл дараа нь ордог болсны дээр сүүлийн жилүүдэд чихрийн шижин өвчний тархалт нэмэгдэх хандлагатай байгааг манай судлаачид тогтоогоод байна.

Судалгаагаар насанд хүрэгсдийн 3.2 хувь буюу 30 гаруй мянган хүн чихрийн шижингийн П хэлбэрээр өвчилсөн, цаашид 9.2 хувь буюу 60 гаруй мянган хүн өвчлөх эрсдэлтэй байгааг тогтоогоод байна.

Хүн амын нас баралтын шалтгааны дотор халдварт бус өвчин давамгайлж монгол хүний дундаж наслалтад ч нөлөөлж байна. Тухайлбал, 1990 онд монгол хүний дундаж наслалт 63.7 байснаа 1992 онд 62.8 болж бууран 2003 онд 63.6, 2004 онд 64.5 болж нэмэгдсэн хэдий ч дундаж наслалтад тодорхой өөрчлөлт гарахгүй байна.

Эрүүл мэндийн статистик үзүүлэлтээр зүрх судасны өвчнөөс шалтгаалсан нийт нас баралтын дотор 43.1 хувийг цусны даралт ихдэх өвчин, тархины цус харвалт, 30.7 хувийг зүрхний цус хомсдох өвчин тус тус эзэлж байна.

Манай улсын 100000 хүн амд дунджаар 134.5 хүн хорт хавдраар өвчилж байгаа бөгөөд энэ өвчин нь ажил, амьдралын туршлага сууж, ид хөдөлмөрлөх насныханд илүү тохиолдож, шинээр оношлогдсон тохиолдлын 70 гаруй хувь нь Ш-IV үедээ буюу хожуу оношлогдсоноос тухайн жилдээ нас барж байна.

Халдварт өвчний тархалт өндөр хэвээр байгаа бөгөөд сүрьеэгийн өвчлөл нэмэгдэж бус

нутагтаа Монгол Улс өндөр тархалттай орны тоонд багтаж байна.

Бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын халдвар сүүлийн жилүүдэд нэмэгдэх хандлагатай болж нийт халдварт өвчний 43.6 хувийг эзэлж байна.

Зах зээлийн тогтолцоонд шилжсэнээс хойш эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авах хөрөнгийн хэмжээ эрс буурч тоног төхөөрөмжийг засварлах, шинэчлэхэд зарцуулах хөрөнгө хомсдох болсон. Аймаг, сумдын эмнэлгийн 50 орчим хувь нь зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, эмнэлэгт байгаа тоног төхөөрөмжийн 80 орчим хувь нь 20 гаруй жил ашиглагдаж байгаа нь хүн амд хүргэх эмнэлгийн тусламжийн чанарт сөргөөр нөлөөлж байна.

Орон нутагт эмнэлгийн мэргэжилтэн дутагдалтай, тэдгээрийн тогтвор суурьшил муу, төгсөлтийн дараахь сургалт хангалтгүй, эмч, эмнэлгийн ажилтны цалин хөлс бага зэрэг нь тусламж үйлчилгээний чанарт шууд нөлөөлж байна. Хөдөө орон нутагт ажиллах эмч нарын тоо эрс цөөрч 100 гаруй сумын эмнэлэгт эмч дутагдалтай байгаагийн зэрэгцээ 15 сумын эмнэлэг их эмчгүй байна.

Ийнхүү хөдөө орон нутгийн эмнэлгийн тусламжийн чанар, хүртээмж хангалтгүй байгаа нь хүн амын дунд далд өвчлөл ихсэх улмаар Улаанбаатар хотод ирж үйлчлүүлэх хөдөөгийн иргэдийн урсгалыг нэмэгдүүлэх шалтгаан болж байна. Энэ нь нэг хэсэг иргэдэд эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн нэмэлт дарамт учруулж ядууралд хүргэх нэг шалтгаан болж байгаа бол амьжиргааны түвшин доогуур, замын зардлаа төлж дийлэхгүй байгаа иргэд эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг авч чадахгүйд хүргэж байна.

Иймээс олон нийтийг хамарсан эрүүл мэндийн үзлэг, оношилгоог нийслэл, орон нутагт зохион байгуулж хүн амын далд, оношлогдохгүй байгаа халдварт болон халдварт бус өвчнийг илрүүлж, эмчлэн эрүүлжүүлэх тусгай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

## **Хөёр. Хөтөлбөрийн зорилго, хугацаа, зарчим, санхүүжилт**

2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн түвшинг тогтоон эрт илрүүлэн эмчилснээр хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөр нь 2006-2008 онд хэрэгжинэ.

2.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

а/иргэдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан эрүүлжүүлэх үйл ажиллагаа нь тасралтгүй шинжтэй байх;

б/үзлэг явуулах үеэр орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, хэвийн явагдах;

в/үзлэгт иргэдийг бүрэн хамруулах; г/иргэдийн хувийн нууцыг хадгалах; д/хөтөлбөр нь төрийн захиргаа, нутгийн өөрөө удирдах, эрүүл мэндийн болон бусад байгууллага, хамт олон, гэр бүл, иргэний нэгдмэл үйл ажиллагаагаар хэрэгжих.

2.4. Хөтөлбөрийн санхүүжилтийг дараахь эх үүсвэрээс бүрдүүлнэ:

а/улсын төсөв (2007 оноос);

б/гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

в/ олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хандив;

г/ бусад эх үүсвэр.

## **Гурав. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн**

3.1. Зорилт 1. 15-аас дээш насны хүн амын дунд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийж зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн түвшинг тогтооно:

3.1.1. Төрөлжсөн мэргэжлийн эмч нарын болон лабораторийн явуулын баг бүрдүүлэх;

3.1.2. Үзлэгийг зохион байгуулахад шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, эм хэрэгслийн захиалга, ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах;

3.1.3. Үзлэгийг батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулж нийт хүн амын 60-аас доошгүй хувийг үзлэгт хамруулж өвчлөлийн түвшинг тогтоох.

Хүрэх үр дүн: 15-аас дээш насны хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн түвшин тогтоогдсон байна.

3.2. Зорилт 2. Үзлэгээр илэрсэн өвчтэй хүмүүсийг эмчилж эрүүлжүүлэх арга хэмжээ авна:

3.2.1. Үзлэг, оношилгоог явуулж оношийг өвчтөн бүрээр тогтоон зөвлөгөө өгч боломжтой эмчилгээг тухай бүр газар дээр нь хийх;

3.2.2. Сум, өрхийн эмнэлгийн эмч нартай хамтарч өвчтөн бүрээр "эрүүлжүүлэх төлөвлөгөө"-г боловсруулж хэрэгжүүлэх;

3.2.3. Удаан хугацааны эмчилгээ шаардлагатай өвчтөнийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллага болон эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэжлийн байгууллагад эмчлүүлэх чиглэл өгөх.

Хүрэх үр дүн: Тухайн орон нутагт ажилласан үзлэгийн баг нь үзлэгээр илэрсэн өвчтэй хүмүүсийн онцлог, хэрэгцээнд нийцсэн "эрүүлжүүлэх төлөвлөгөө"-г сум, өрхийн эмч нартай хамтран иргэн нэг бүрээр боловсруулсан байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг арга зүйгээр хангах, хяналт-үнэлгээ хийх, хүн амыг эрүүлжүүлэх ажлыг Эрүүл мэндийн яам, орон нутгийн эрүүл мэндийн газар дэс дараатай зохион байгуулсан байна. Эдгээр арга хэмжээний үр дүнд зарим өвчтөн эмчилгээ хийлгэж эрүүлжсэн байна.

3.3. Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн мэдээллийн цахим сан байгуулна:

3.3.1. Мэдээлийн сан үүсгэх бэлтгэл ажлыг зохион байгуулах;

3.3.2. Үзлэгт хамрагдсан иргэн бүрийн өвчлөлийн талаар мэдээллийг цахим санд оруулах;

3.3.3. Хүн амын 60 хувийг хамарсан улсын хэмжээний нэгдсэн сан байгуулж мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж гаргах боломжийг бүрдүүлэх;

3.3.4. Мэдээллийн санд үндэслэн иргэдийг эмчилгээ, үйлчилгээнд хамруулах боломж бүрдүүлэх.

Үр дүн: Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөлийн мэдээллийн цахим сан байгуулагдаж мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бодлогын зөвлөмж гаргах, иргэдийг үзлэгт хамруулах боломж бүрдсэн байна.

3.4. Зорилт 4. Хүн амын дунд эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр сургалт, сурталчилгаа явуулна:

3.4.1. Үзлэгийн үеэр хүн амд зориулан эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгаа явуулах;

3.4.2. Шаардлагатай тохиолдолд өвчтөнд үзлэгийн багийн эмч, мэргэжилтний зүгээс ганцаарчилсан зөвлөгөө өгөх;

3.4.3. Орон нутгийн эмч, эмнэлгийн ажилтныг дагалдуулан сургах, тэдний үр чадварыг дээшлүүлэх.

Үр дүн: Эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар иргэд тодорхой мэдлэг ойлголттой болсон байна.

3.5. Зорилт 5. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд үнэлгээ, дүгнэлт өгч, цаашид азгш арга хэмжээний талар санал боловсруулах:

3.5.1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал, явуулж байгаа үйл ажиллагаанд үнэлгээ хийх;

3.5.2. Тухайн орон нутгийн хүн амын өвчлөлийн түвшин, онцлогт тохирсон үйл ажиллагаа явуулах хүчин чадлыг бий болгох чиглэлээр санал боловсруулах.

Үр дүн: Тухайн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг хүн амынхаа эрүүл мэндийн хэрэгцээтэй уялдуулан цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргана.

## Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд уялдуулан зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах арга хэмжээг Эрүүл мэндийн яам хариуцан зохион байгуулна.

4.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, хэрэгжүүлэх, үр дүнд хяналт тавих үүргийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хариуцна.

4.3. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад оролцож хүн амыг эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, үр дүнд тооцох, тайлагнах үүрэг хүлээнэ.

## Тав. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Хөтөлбөрт 21 аймаг, 329 сум болон Улаанбаатар хотын 15-аас дээш насны хүн амын 60-аас доошгүй хувь буюу нийт 1.6 сая орчим хүн хамрагдана.

## Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтэд тавих хяналт, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг улсын хэмжээнд Эрүүл мэндийн яам, орон нутагт аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцан гүйцэтгэнэ.

6.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын талаар жил бүрийн I улиралд багтаан Эрүүл мэндийн яаманд мэдээлнэ.

6.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар жил бүрийн II улиралд багтаан Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл, Засгийн газарт мэдээлж хөтөлбөрийн үнэлгээг 2006-2008 онд дараахь шалгуур үзүүлэлтээр гаргана.

## Хөтөлбөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	2006	2007	2008	Мэдээллийн эх үүсвэр
1.	Үзлэгт хамрагдвал зохих хүн амаас хамрагдсан хүмүүсийн эзлэх хувь	30	60	100	Үзлэгийн тайлан
2.	"Эрүүлжүүлэх төлөвлөгөө"-нд иргэдээ бүрэн хамруулсан сум, өрхийн эмнэлгийн эзлэх хувь	20	40	100	Орон нутгийн захиргаа, эрүүл мэндийн байгууллагын тайлан
3.	Зонхилон тохиролдох халдварт болон халдварт бус өвчний өвчлөлийн мэдээллийн цахим санд хамрагдсан өрх, сумын эмнэлгийн эзлэх хувь	20	60	100	Мэдээний сангийн тайлан
4.	Эрүүл аж төрөх, өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгаанд хамрагдсан хүмүүсийн эзлэх хувь	30	60	100	Мэдээлэл, сургалт, сурталчилгааны тайлан
5.	Орон нутгийн хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн төлөвлөгөө боловсруулалт хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь	20	60	100	Орон нутгийн захиргаа, эрүүл мэндийн байгууллага, нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн тайлан

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

### Хөтөлбөр батлах тухай

Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт мал аж ахуйн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Малын чанар сайжруулах хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор баталсугай.

2. Малын чанар сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Малын чанар сайжруулах хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, жил бүрийн төсвийн багцад тусгах болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн

жагсаалтад санал болгон оруулах замаар хэрэгжүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Тэрбишдагва, Сангийн сайд Н.Баяртсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 105 дугаар тогтоол, "Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2002 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 141 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ  
АХУЙН САЙД

Д.ТЭРБИШДАГВА

Засгийн газрын 2006 оны 93 дугаар тогтоолын хавсралт

### МАЛЫН ЧАНАР САЙЖРУУЛАХ ХӨТӨЛБӨР

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Мал үржлийн ажил, үйлчилгээний өнөөгийн байдал

Засгийн газраас 1997 онд "Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах" үндэсний хөтөлбөр, 2002 онд "Шилмэл хээлтүүлэгч" дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлсний үр дүнд малын чанар, ашиг шимийг дээшлүүлэх ажилд ахиц

дэвшил гарсаар байна. Цөм сүргийн мал 912.0 мянгад хүрч, жил бүр 14.0-15.7 мянган өсвөр хээлтүүлэгч бойжуулж сүрэг сэлбэснээр хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо сайжирч, малын сувайралт 8.7 пунктээр буурч, 100 эхээс бойжуулах төлийн тоо 15-24-өөр нэмэгдэв. Манай улс малын төрөл, ашиг шимийн чиглэлээр өөр хоорондоо ялгаатай 50 шахам үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг,

омог, хэвшлийн малыг үржүүлж байна. Статистикийн мэдээгээр 2005 оны эцсийн байдлаар нийт малын 1.01 хувь буюу 309.2 мянган хээлтүүлэгч байна.

Гэвч нийт хээлтүүлэгчийн 19.8 хувь нь стандартын шаардлага хангахгүй байна. Мал үржлийн ажилд дэвшилт арга, технологи нэвтрүүлэх, хээлтүүлэгчийг баталгаажсан цөм сүргээс бойжуулж үржилд ашиглах, үржил селекцийн мэдээллээр малчид, мал аж ахуй эрхлэгчдийг үйлчлэх тогтолцоо бүрдүүлэх, үржилд ашиглагдах багаж хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлэх, үржлийн ажил, үйлчилгээний зохион байгуулалтыг сайжруулахад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн идэвхтэй оролцоог дээшлүүлэх нь онцгой ач холбогдолтой юм.

2. Хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2003 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого"-ын баримт бичигт "монгол малын тэсвэрт чанарыг бататган биологийн боломжийг нь бүрэн ашиглах, зүй бус хорогдол, хээл хаялт, сувайралтыг багасгах замаар үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлэх" болон "нутгийн шилдэг омгийн цөм сүрэг, арвин ашиг шимт мал, амьтны шалгарсан удмыг сайжруулагчаар ашиглах, биотехнологи, генийн инженерчлэлийн дэвшилт аргыг нэвтрүүлж малын үүлдэрлэг байдлыг сайжруулах" зорилтуудыг дэвшүүлсэн.

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуульд заасан "малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх цогцолбор арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх" нь Засгийн газрын үүрэг юм.

Засгийн газрын 2004-2008 оны үйл ажиллагааны хөтөлбөрт "... эрчимжсэн хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх болон мал үржлийн ажлын чанар, хүртээмжийг сайжруулах", "гойд чанертай шилмэл үүлдэр, омгийн мал, амьтны зорилтот зах зээлийг бий болгох санал, санаачилгыг дэмжих"-ээр тусгагдсан болно.

3. Малын чанар, үржлийн ажил, үйлчилгээг сайжруулах чиглэлээр олсон ололт амжилт, туршлага, сургаж

Аймаг, суманд бүх мал сүрэгт арвин ашиг шимт малыг сайжруулагчаар ашиглаж олон арван шинэ үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсгийн мал, амьтдыг шинээр бий болгон баталгаажуулж өөрийн орны төдийгүй дэлхийн мал сүргийн удмын санг баяжуулж байна. Гэвч сүүлийн жилүүдэд мал сүргийг сонгон үржүүлэх шинжлэх ухааны үндэслэлтэй мэргэжлийн ажил, үйлчилгээг хэрэгжүүлэх бүтэц, тогтолцоо алдагдаж, малын чанар сайжруулахад хөрөнгө санхүү хомсдож, малчид, мал аж ахуй эрхлэгчдийн хамтын ажиллагаа дутмаг байгаа нь цаашид анхаарах чухал сургаж болж байна.

**Хоёр. Хөтөлбөрийн эрхэм зорилго, тэргүүлэх чиглэл, зарчим, үржлийн чиглэл**

4. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь мэргэжлийн албадын чадавхийг бэхжүүлэх замаар малын чанарыг сайжруулах, удмын санг хамгаалах, мал үржлийн ажилд дэвшилт арга, технологи нэвтрүүлэхэд оршино.

5. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь тэргүүлэх чиглэлийг баримтална:

5.1. Үндэсний хэмжээнд мал үржлийн албаны чадавхийг бэхжүүлэх;

5.2. Цөм сүрэг, гойд ашиг шимт малыг өсгөж, удамшлын чадавхийг дээшлүүлэх;

5.3. Малчин өрхийн орлого, амьжиргааны түвшинг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах;

5.4. Мал сүргийг эрсдэлээс хамгаалах тогтолцоог сайжруулах.

6. Хөтөлбөрийн үйл ажиллагааг дор дурдсан үндсэн зарчимд тулгуурлан хэрэгжүүлнэ:

6.1. Мал аж ахуйн хөгжлийн бодлогыг төрийн бодлоготой уялдуулах зарчим: Үржлийн бодлого, үйл ажиллагааг мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлого, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, байгаль цаг уурын онцлогт нийцүүлэх;

6.2. Төр засгийн дэмжлэгийн зарчим: Мал аж ахуй эрхлэгчдийн тогтвортой хөгжлийг хангах эдийн засаг, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;

6.3. Малын чанар, сүргийн бүтцийг оновчтой болгож, тогтвортой хадгалах зарчим: Бүс нутгийн онцлог, бэлчээрийн даац багтаамжид тохируулан малын төрөл хоорондын зохистой харьцаа болон сүргийн оновчтой бүтцийг бий болгож, стандартын шаардлага хангасан хээлтүүлэгчийг үржилд ашиглах;

6.4. Мэдээлэл хүртээмжтэй байх зарчим: Сум, аймаг, улсын хэмжээнд мал сүргийн үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарц, чанарын талаархи бүртгэл, мэдээллийн сүлжээг бий болгож, мэдээллийг нээлттэй, хүртээмжтэй байлгах;

6.5. Мэргэшилд түшиглэх зарчим: Малын чанар сайжруулах ажил, үйлчилгээг мэргэжлийн байгууллага, мэргэжсэн ажилтны удирдлага, шинэ технологид түшиглэн явуулах.

7. Мал сүргийг доорхи чиглэлээр сонгон үржүүлнэ:



7.1. Монгол адууг уналга эдэлгээний болон хурдлах чадварыг нь дээшлүүлэх, мах, сүүн ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр үржүүлэхийн зэрэгцээ гадаадын төрөлжсөн үүлдрийн адууг хязгаарлагдмал хүрээнд сайжруулагчаар ашиглах;

7.2. Тэмээг ноос, сүүн ашиг шимийг нэмэгдүүлэх, уналга эдэлгээ, хязгаарлагдмал хүрээнд хурдлах чадавхийг дээшлүүлэх чиглэлээр сонгон үржүүлэх;

7.3. Монгол үхэр, сарлагийг мах, сүүний чиглэлээр сонгон үржүүлэхийн зэрэгцээ ойт хээр болон хээрийн бүсэд хурдан өсөлттэй, махны чиглэлийн үүлдэр, төвлөрсөн хот суурингийн ойролцоох эрчимжсэн аж ахуйд сүүний чиглэлийн арвин ашиг шимт үхэр үржүүлэх;

7.4. Нутгийн үүлдэр, омгийн хонийг махны болон хивсний ноосны чиглэлээр үржүүлэх, бэлчээр, тэжээлийн бололцоотой бүс нутагт арвин ашиг шимт нарийн, нарийвтар ноост, махны чиглэлийн төрөлжсөн үүлдрийн хонь үржүүлэх;

7.5. Ямааг ноолуур, мах, сүү, ноосны ашиг шимийн чиглэлээр бүс нутгаар төрөлжүүлэн үржүүлэх;

7.6. Бүсийн тулгуур төв болон нийслэл, томоохон хот суурингийн ойролцоо гахайг мах-өөх, махны чиглэлээр, шувууг өндөг, үржлийн дэгдээхэй бойжуулах чиглэлээр эрчимжсэн технологиор үржүүлэх.

## Гурав. Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, үйл ажиллагаа

8. Зорилт 1. Цөм сүргийг баталгаажуулан бүртгэлжүүлж, үржил, ашиг шимийн мэдээллийн сан, тогтолцоо бий болгоно.

### 8.1. Хүрэх үр дүн

8.1.1. шинжлэх ухааны үндэслэлтэй үржлийн ажил, үйлчилгээ явуулах нөхцөл сайжирч, улсын бүртгэл, мэдээллийн сан бүрдэж, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын нэгдсэн сүлжээнд хамрагдах боломжтой болно.

### 8.2. Үйл ажиллагаа

8.2.1. Монгол Улсад үржүүлж байгаа баталгаажсан үүлдэр, омгийн малыг нэгдсэн бүртгэлтэй болгож, ашиглах бүс, нутгийг тогтоох;

8.2.2. нийт хээлтүүлэгч, цөм сүргийн хээлтэгч малын үржил, ашиг шимийн чанарт үнэлгээ хийж бүртгэлжүүлэн хувийн дугаар, гэрчилгээтэй болгох;

8.2.3. баталгаажсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах, худалдан борлуулах сүлжээ бий болгох;

8.2.4. малын чанар үнэлэх болон бүртгэл, мэдээлэл нэвтрүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, програмын хангамж, компьютерийн сүлжээ, өгөгдлийн хүрэлцээг үндэсгдүүлэх;

8.2.5. баталгаажсан цөм сүрэг, жишигт тэнцсэн хээлтүүлэгчийн үржил, ашиг шимийн үзүүлэлтээр аймаг, улсын түвшинд мэдээллийн сан бүрдүүлж, үндэсний нэгдсэн сүлжээнд хамруулан хэрэглэгчдийг мэдээллээр хангах боломж бүрдүүлэх;

8.2.6. үржлийн малыг ашиг шимийн чанараар баталгаажуулах, бүртгэл, мэдээллийн сан, сүлжээ бий болгон нэвтрүүлэхэд мэргэжлийн чиглэлийн төрийн бус байгууллагын оролцоог дэмжих.

9. Зорилт 2. Малын удмын сангийн нөөцийг баяжуулна.

### 9.1. Хүрэх үр дүн

9.1.1. цөм сүргийн малын үржлийн төвүүд бий болж, стандартын шаардлага хангасан хээлтэгч, хээлтүүлэгч үржүүлж үр, хөврөл үр зэрэг үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

### 9.2. Үйл ажиллагаа

9.2.1. малын удамшлын нөөц, чадавхийг зохистой ашиглах үржлийн ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

9.2.2. цөм сүргийн малыг сонгон үржүүлэх үржлийн төвүүд бий болгож, үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн хэрэгцээнд нийлүүлэх;

9.2.3. гадаадаас үржлийн мал, амьтан, тэдгээрийн үр, хөврөл үр импортлоход тавих шаардлагыг тогтоож мөрдүүлэх;

9.2.4. малын чанар сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх чиглэлээр амжилт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг жил бүр шалгаруулан урамшуулах, арга туршлагыг нь дэлгэрүүлэх;

9.2.5. тоо нь цөөрч байгаа үүлдэр, омог, хэвшлийн малын удмын санг сэргээх, тэдгээрийн үр, хөврөл үрийг генийн санд хадгалах, шинэчлэх, зохистой ашиглах ажлыг зохион байгуулах;

9.2.6. хөврөл үр үйлдвэрлэх, хүйс жолоодох чиглэлээр шинжлэх ухаан, технологийн дунд болон урт хугацааны төсөл хэрэгжүүлэх;

9.2.7. шилмэл хээлтүүлэгчийг чиглэлтэй бойжуулах, үр төлийнх нь чанараар үнэлж шалгах, иммуногенетикийн аргаар удам гарвалыг нь тодорхойлоход шаардагдах багаж, тоног төхөөрөмжөөр үржлийн төвийг хангах чиглэлээр дэмжлэг үзүүлэх;

9.2.8. малын зохиомол хээлтүүлгийн орчин үеийн дэвшилт технологийг эрчимжсэн аж ахуйд өргөн хэрэглэж, хээлтүүлэгчийг ашиглах.



10. Зорилт 3. Малын чанар, ашиг шимийг дээшлүүлэх, малчин өрхийн аж ахуйг эрсдэлээс хамгаалах эдийн засаг, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.

## 10.1. Хүрэх үр дүн

10.1.1. мал үржлийн ажил, үйлчилгээ сайжирч, үр дүн нь дээшилж мал аж ахуй эрхлэж буй өрхийн орлого нэмэгдэж эрсдэл даах чадавхитай болсон байна.

## 10.2. Үйл ажиллагаа

10.2.1. малын удмын санг хамгаалах эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

10.2.2. мал үржлийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд эрхлэх нэгжийн үйл ажиллагааны стандарт бий болгох;

10.2.3. үржлийн өсвөр мал бойжуулах, борлуулах үйл ажиллагаа эрхлэх зохистой тогтолцоо бүрдүүлэх;

10.2.4. үржлийн хээлтүүлэгч бойжуулах чиглэлтэй цөм сүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллага, малчдыг сонгон шалгаруулж, тэдгээрийг дэмжих, урамшуулах хөшүүрэг бий болгох;

10.2.5. цөм сүрэг бүрдүүлэх, үржлийн хээлтүүлэгч бойжуулах, импорт орлох үржлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх чиглэлээр төсөл сонгон шалгаруулж дэмжлэг үзүүлэх, гадаад дотоодын хөтөлбөр, төсөлд хамруулах арга хэмжээ авах;

10.2.6. хээлтэгч, хээлтүүлэгчийн тохиороог малын төрөл, ашиг шимийн чиглэл, хээлтүүлгийн аргатай уялдуулан бүсчлэн шинэчлэн тогтоож, мөрдөх;

10.2.7. хадлан, тэжээлийн ургамлыг усалгаатай нөхцөлд тариалах сонирхлыг урамшуулах замаар тэжээлийн хангамжийг сайжруулах;

10.2.8. тэжээлийн болон бэлчээрийн олон наст ургамлын үр үржүүлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэж байгаа иргэд, аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх;

10.2.9. уураг, энергийн агууламж өндөртэй тэжээл үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх санаачилгыг хөхиүлэн дэмжих;

10.2.10. бэлчээрийг зохистой ашиглах талаар малчид, мал бүхий иргэдээс гарсан үүсгэл санаачилгыг дэмжих;

10.2.11. бэлчээрийн шинэ удирдлагыг хэрэгжүүлж байгаа малчдын бүлэг, хоршооны санаачилгыг дэмжиж мал маллагааны уламжлалт технологитой хослуулан хэрэглэх;

10.2.12. үржлийн цөм сүрэг, хээлтүүлэгчийг мал эмнэлгийн үзлэг, шинжилгээнд тогтмол хамруулж малыг эрүүлжүүлэх арга хэмжээг авах.

11. Зорилт 4. Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхлэх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн

чадавхийг дээшлүүлж, үр дүнг сайжруулна.

## 11.1. Хүрэх үр дүн

11.1.1. мал үржлийн ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагын мэргэшлийн чадавхи, ажлын үр өгөөж сайжирч, бүтээмж дээшлэн мал бүхий иргэдийн орлого нэмэгдэнэ.

## 11.2. Үйл ажиллагаа

11.2.1. малыг шилэх, тохируулан сонгох, үр төлийн чанараар нь үнэлэх чадавхитай мэргэшсэн шинжээч, зохиомол хээлтүүлгийн технологич бэлтгэх, дадлагажуулах, давтан сургах;

11.2.2. малын чанар, үржлийн ажилд үнэлгээ өгч, үржлийн ажлын хөтөлбөр, зөвлөмж, аргачлал, технологи боловсруулж мал үржүүлэгчдэд мэдлэг түгээх сургалт, сурталчилгаа явуулах;

11.2.3. бог малын хээлтүүлэгчийг тусгайлан суурилж малчдад гэрээгээр үйлчилгээ үзүүлэхийг дэмжих;

11.2.4. малын үр, хөврөл үр үйлдвэрлэх, шилжүүлэн суулгах орчин үеийн лабораторийг шинээр байгуулж, явуулын лабораторийн үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөх;

11.2.5. хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг гадаад орон, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрүүдтэй уялдуулан зохион байгуулах;

11.2.6. малын үзэсгэлэн худалдааг сум, аймаг, улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг олон улсын жишигт нийцүүлэн боловсронгуй болгох;

11.2.7. малын удмын сангийн үндэсний төв, аймгийн малын үржлийн алба, цөм сүргийн үржлийн төвийн чадавхийг бэхжүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх;

11.2.8. малын үржлийн ажил, үйлчилгээг сумын түвшинд эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих;

11.2.9. мал үржлийн чиглэлээр ажил, үйлчилгээ эрхэлдэг байгууллага болон төрийн бус байгууллагаар төрийн зарим чиг үүргийг гүйцэтгүүлэх ажлыг өргөжүүлэх;

11.2.10. мал үржлийн ажил, үйлчилгээний зориулалттай багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хангамжийг дээшлүүлж, анхан шатны нэгжид ажилладаг мэргэжилтнүүдийн мэргэшил, үр чадварыг сайжруулах.

## **Дөрөв. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат, удирдлага, зохион байгуулалт**

### 12. Хөтөлбөр хэрэгжүүлэх үе шат, хугацаа

12.1. Хөтөлбөрийг 2006-2015 онд дараахь гурван үе шатаар хэрэгжүүлнэ;

12.1.1. Эхний үе шат 2006-2008 он;

12.1.2. Хоёр дахь үе шат 2008-2012 он;  
12.1.3. Гуравдахь үе шат 2012-2015 онд хэрэгжинэ.

13. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

13.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах үүргийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага эрхэлнэ.

13.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд хөтөлбөрийн хэрэгжилтийг тухайн шатны Засаг дарга хариуцна.

13.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөг улсын хэмжээнд хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн шатны Засаг дарга боловсруулж хэрэгжүүлнэ.

13.4. Хөтөлбөрт тусгагдсан үржлийн чиглэл, үйл ажиллагааг малчид, мал бүхий иргэд, мал эмнэлэг, үржлийн анхан шатны нэгж, судлаач, мэргэжилтэн нар хариуцан энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг төрийн бус байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

13.5. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааг Малын эрүүл мэнд, Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих, Хүнсний хангамж, аюулгүй байдал, хоол тэжээл, Экологийн цэвэр бүтээгдэхүүн зэрэг хөтөлбөрүүд болон бусад салбарт хэрэгжүүлж байгаа үндэсний хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан зохицуулна.

13.6. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийн талаар олон улсын болон гадаадын байгууллага, сонирхогч талуудад мэдээлж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрт тусган ажиллана.

## Тав. Хөтөлбөрийн мэдээлэл, сурталчилгаа, судалгаа

14. Үндэсний хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагааны явц, үр дүн болон мал сүргийн чанар сайжруулах чиглэлээр амжилт олж байгаа аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг хөтөлбөрт хамрагдаж байгаа байгууллага хариуцан зохион байгуулна.

15. Малын чанарыг сайжруулах чиглэлээр дараахь төслүүдэд тэргүүлэх ач холбогдол өгч дэмжинэ:

15.1. Малын нөхөн үржихүйн биотехнологи;

- 15.2. Малын генийн сан;
- 15.3. Бүртгэл, мэдээллийн сан, сүлжээ;
- 15.4. Үржлийн төв, үйлчилгээний нэгжийн чадавхийг дээшлүүлэх;
- 15.5. Малын тэжээлийн хангамжийг сайжруулах;
- 15.6. Үхэр, хонины мах үйлдвэрлэлийг эрчимжсэн аргаар нэмэгдүүлэх;
- 15.7. Тэмээ, сарлаг, цаа бугын удмын санг хамгаалах;
- 15.8. Цөм сүргийг эрсдэлээс хамгаалах.

## Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт, тайлан, мэдээ

16.1. Хөтөлбөрийг дараахь эх үүсвэрээр санхүүжүүлнэ:

- 16.1.1. мал бүхий иргэдийн хөрөнгө;
- 16.1.2. аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө;
- 16.1.3. улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;
- 16.1.4. хандивлагч орон болон олон улсын байгууллагын эзэл, тусламж, хандивын хөрөнгө;
- 16.1.5. хөдөө аж ахуйн тусгай зориулалтын сангийн хөрөнгө;
- 16.1.6. бусад эх үүсвэр.

16.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шатанд шаардагдах зардлын тооцоог хавсаргав.

17. Хөтөлбөрийн санхүүжилтийн тайлан, мэдээлэл

17.1. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, түүний хуваарилалт, зарцуулалтад тавих хяналт шалгалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

17.2. Хөтөлбөрийн санхүүжилтийн мэдээ, тайланг холбогдох байгууллага болон хандивлагч, ивээн тэтгэгчид мэдээлж байна.

## Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ, шалгуур үзүүлэлт

18. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зохион байгуулалт

18.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний гол зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааг үр дүн, үр нөлөөтэй нь холбон дүгнэж, арга туршлага, сургамжийг нэгтгэхэд оршино.

18.2. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээг төлөвлөгөөний дагуу аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгж хэрэгжүүлнэ.

19. Хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараахь шалгуур үзүүлэлтийг ашиглана:

Шалгуур үзүүлэлтүүд		Суурь үзүүлэлт (2005 он)	Завсрын үзүүлэлт (2008 он)	Эцсийн үзүүлэлт (2015 он)	
А		1	2	3	
<b>Нэгдүгээр зорилтын хүрээнд:</b>					
1. Бүртгэлд авсан үүлдэр, цөм сүргийн тоо (мян.тол)		917.0	1000.0	1500.0	
2. Баталгаажсан хээлтүүлэгч (хувиар)		80.2	90.0	100.0	
3. Бүртгэл мэдээллийн сан, сүлжээнд хамрагдсан нэгжийн тоо		0	22	38	
4. Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо					
Үүнээс	Буур	22	21	21	
	Азарга	7	8	9	
	Бух	28	26	20	
	Хуц	53	45	35	
	Ухна	51	45	35	
<b>Хоёрдугаар зорилтын хүрээнд:</b>					
5. Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа эрх бүхий		Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн	50	100	250
		Үржлийн төв	1	6	22
6. Үржилд бойжуулсан малын тоо (мян.тол)		Хээлтүүлэгч	146.0	175.2	227.7
		Хээлтэгч	255.3	306.3	398.3
7. Үйлдвэрлэсэн үржлийн бүтээгдэхүүний тоо		Үр	9700	20000	160000
		Хөврөл үр	0	200	1500
8. Гадаадаас авсан (тоо)		Мал	100	3000	700
		Үр, хөврөл үр	17400	20000	30000
9. Нийт малд цэвэр, эрлийз, нутгийн шилдэг омгийн малын эзлэх хувь			8.4	9.0	11.3
<b>Гуравдугаар зорилтын хүрээнд:</b>					
10. Шинээр боловсруулсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан эрх зүйн баримт бичгийн тоо			4	3	8
11. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс зарцуулсан хөрөнгийн хэмжээ (сая.төг)			140.0	1995.5	3850.0
12. Гадаадын болон Олон улсын төсөл, хөтөлбөрт хамрагдсан байдал, санхүүжилт		Тоо (ам.доллар,мян)	3	4	6
			200.0	300.0	800.0
13. Тээвэрийн жижиг, дунд үйлдвэр			0	2	5
14. Тээвэрийн болон олон наст ургамлын үр үржүүлэх аж ахуй			0	2	4
<b>Дөрөвдүгээр зорилтын хүрээнд:</b>					
15. Мэргэжилтний хангамж, чадамж	Мал үржлийн ажил, үйлчилгээ эрхэлж байгаа мэргэжилтний тоо		98	150	250
	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан (тоо)		50	200	450
	Давтан сургалтад хамрагдсан (тоо)		120	400	950
16. Үйлчилгээний нэгжийн чадамж	Үржлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон малын ашиг шимийн гарц чанар тодорхойлох лаборатори		1	5	22
	Зохиомол хээлтүүлгийн салбарын тоо		30	45	60
	Тоног төхөөрөмжөөр хангагдсан хувь		10.0	30.0	100.0
	Сүлжээнд холбогдсон үржлийн алба, үржил-селекцийн төв		1	5	22

## 20. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний арга

үнэлгээний арга

20.1. Ажлын тайлан-зорилтын хэрэгжилт, ололт амжилт, алдаа доголдол, түүний шалтгаан, нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг тусгасан жилийн болон тухайн хугацааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.

20.2. Тусгайлан судалгаа, шинжилгээний ажил: хөндлөнгийн шинжээчдээр бодит баримт, тэдгээрийн шалтгааныг хамтад нь тусгасан дэлгэрэнгүй мэдээ, мэдээлэл, дүгнэлтийг хөтөлбөрийн үр дүнтэй шууд холбон судалж харьцуулан дүгнэнэ.

20.3. Нөхцөл байдлын шинжилгээ: нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлнэ.

20.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хэлэлцэх семинар, уулзалт: гүйцэтгэлийн үр дүнд тулгуурлан хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг хэлэлцэн дүгнэж арга туршлага, сургажжаа нэгтгэн дүгнэнэ.

## 20.5. Зөвлөмж: Үе шат бүрийн зорилтын

хэрэгжилтэд холбогдох санхүүгийн мэдээллийг ашиглан шинжилгээ хийж, хандивлагч, санхүүжүүлэгчдийг мэдээллээр хангана.

20.6. Шалгалт: хөтөлбөрийн зорилтыг биелүүлэх үйл ажиллагаа нь зохих хууль тогтоомж, төлөвлөгөөний дагуу үр дүнтэй явагдаж байгаа эсэхийг ажлын хэсэг газар дээр нь шалгана.

## 21. Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан

21.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар жил бүрийн 1 дүгээр сард аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар 2 дугаар сарын 15-ны дотор хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус тайлагнана. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тайланг нэгтгэж жил бүрийн эхний улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.



## ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХНИЙ ҮЕ ШАТАНД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Сая											
		2006					2007						
		ЭГД	УЛСЫН ТӨСВӨ	ТӨСВӨДӨН ХАЛГАА	ХАЛГАА ХАМТ ХАМГААРАХ ЭРХЭМ ЭРХЭМ	ЭГД	УЛСЫН ТӨСВӨ	ТӨСВӨДӨН ХАЛГАА	ХАЛГАА ХАМТ ХАМГААРАХ ЭРХЭМ ЭРХЭМ	ЭГД	УЛСЫН ТӨСВӨ	ТӨСВӨДӨН ХАЛГАА	ХАЛГАА ХАМТ ХАМГААРАХ ЭРХЭМ ЭРХЭМ
1	Ажлааг суудал, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	120.0	80.0	30.0	50.0	250.0	250.0	20.0	20.0	300.0	250.0	50.0	50.0
2	Үйлдвэр, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	556.0	70.0	33.0	453.0	450.0	150.0	20.0	330.0	400.0	250.0	150.0	100.0
3	Үйлдвэр, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	814.0	140.0	30.0	644.0	800.0	120.0	20.0	750.0	1050.0	140.0	40.0	810.0
4	Голд ажил үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	10.0	10.0	10.0	0.0	87.0	13.0	10.0	60.0	120.0	20.0	20.0	70.0
5	Малын чанар, ажил үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	284.0	20.0	20.0	240.0	220.0	40.0	20.0	150.0	300.0	100.0	50.0	150.0
6	Малын үр үйлдвэр, ажиллагааны орлого, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	210.0	50.0	150.0	10.0	220.0	100.0	100.0	20.0	220.0	50.0	150.0	20.0
7	Малын ажил үйлдвэр, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	200.0	60.0	50.0	190.0	200.0	60.0	50.0	150.0	220.0	50.0	20.0	150.0
8	Сургалт, сурталчилгаа, гарын өмчлөг үзүүлэх (сая тг)	98.0	28.0	10.0	50.0	178.0	28.0	40.0	110.0	70.0	30.0	10.0	30.0
9	Зөвхөн үйлдвэр, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	105.0	70.0	10.0	65.0	200.0	120.0	30.0	60.0	115.0	85.0	20.0	70.0
10	Малд ажиллагааны орлого, үйлдвэр, үйлчилгээний төлөвлөгөөг дэмжлэг үзүүлэх (сая тг)	70.0	10.0	20.0	40.0	50.0	20.0	10.0	60.0	120.0	10.0	30.0	30.0
	Дүн	2000.0	364.0	443.0	1193.0	2470.0	642.0	120.0	1700.0	3218.0	1023.0	180.0	1700.0

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Ажлаас чөлөөлөх, ажилд түр томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 17.12-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2. Цогтын Бат-Энхийг Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргаар түр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

ЗАМ, ТЭЭВЭР, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН САЙД

Ц.ЦЭНГЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

Дугаар 99

Улаанбаатар хот

"Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр" батлах тухай

Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

чиглүүлэх арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

1. "Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэн жил бүрийн П улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД

М.ЭНХБОЛД

БАЙГАЛЬ ОРЧНЫ  
САЙД

И.ЭРДЭНЭБААТАР

Засгийн газрын 2006 оны 99 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

## УДААН ЗАДАРДАГ ОРГАНИК БОХИРДУУЛАГЧИЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

### Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс химийн бодисын аюулгүй байдлын олон улсын гэрээ, хэлэлцээрт нэгдэн орж, тэдгээрийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл

нь Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмийн конвенцид 2004 онд нэгдэн орсон явдал юм.

Байгалийн гаралтай эсхүл хүний үйл ажиллагаагаар үүссэн, онцгой хортой шинж чанар

4	Удаан задардаг органик бохирдуулагчийн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нарыг өндөр хөгжилтэй оронд урт, богино хугацааны сургалтад хамруулах	БОЯ	БСШУЯ	2007 - 2010	ДДБОС, хандивлагчид	100.0
Зургаа. Удаан задардаг органик бохирдуулагчийн хяналт-шинжилгээ болон судалгаа, шинжилгээний чадавхийг бүрдүүлэх талаар:						
1	Удаан задардаг органик бохирдуулагчийн хяналт-шинжилгээ болон судалгаа шинжилгээг гүйцэтгэх чадавхи бүхий лабораторийг байгуулах	БОЯ	СЯ	2008 - 2010	ДДБОС, хандивлагчид	1000.0
2	Удаан задардаг органик бохирдуулагчийн эх үүсвэрүүд төвлөрсөн болон бохирдолтой газруудад тэдгээрийн бохирдлын болон үүсэлтийн зэрэглэлийг ус, агаар, хөрс, хурдаст тогтоож, тэдгээрээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа нөлөөллийн үнэлгээ хийх	БОЯ	ЭМЯ	2010 - 2011	ДДБОС, хандивлагчид. Байгаль хамгаалах сан	30.0
3	Удаан задардаг органик бохирдуулагчийн эх үүсвэрт болон тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнтэй шууд харьцаж ажилладаг эрсдэлтэй бүлгийнхнийг хамруулан судалгаа хийж, өвчлөлийн нийтлэг хандлага, илрэлийг тогтоон, эрсдэлийн үнэлгээ хийх	БОЯ, ЭМЯ	ТЭХЯ, ҮХЯ	2010 - 2012	ДДБОС, хандивлагчид	60.0
4	Нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станц, уурын зуух, гэр хорооллын айл өрхийн зуухнаас үүсэх диоксин болон фураны үүсэлтийн зэрэглэл, түүнийг бууруулах боломжид үнэлгээ хийх	БОЯ	ШУА	2010 - 2012	ДДБОС, хандивлагчид	50.0
5	Удаан задардаг органик бохирдуулагчийн хяналт-шинжилгээг агаар, ус, хөрс, хурдас, хүнсний бүтээгдэхүүнд хийх аргачлалыг боловсруулж, хяналт-шинжилгээний цэгүүд, хэмжилт хийх хугацааг тогтоон байнгын хяналт-шинжилгээний системийг бий болгох	БОЯ	ШУА	2009 - 2011	ДДБОС, хандивлагчид	80.0
<b>ДҮН</b>						<b>5023.3</b>

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.  
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хэвлэл: үзэсгэлт хэвлэл

Улаанбаатар-12  
Төрийн ордон

☎ 265958  
Индекс: 14003

☎ 329487

Хэвлэлийн хуудас 3.5